

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Захиалагч  
байгууллага: “Ойн  
судалгаа хөгжлийн  
төв” УТҮГ



Гүйцэтгэгч  
байгууллага:  
“Хатант Форест”  
ХХК

Улаанбаатар хот

2020 он


## ОЙН НӨӨЦИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 06-р сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлд

“ХЭЛЭЛЦСЭН нь: 3. Говь-Сүмбэр аймгийн ойн менежментийн төлөвлөгөө

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хоёр. Говь-Сүмбэр аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг Ой судалгаа, хөгжлийн төвөөс ирүүлсэн дүгнэлт болон гишүүдийн ирүүлсэн саналыг үндэслэн батлав.” гэжээ.



**АГУУЛГА**

|  |    |
|--|----|
| <b>НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ .....</b>  | 3  |
| 1.1 Танилцуулга .....  | 3  |
| 1.1.1. Говьсүмбэр аймгийн танилцуулга .....                            | 3  |
| 1.1.2. Газар зүйн байрлал .....  | 3  |
| 1.1.3. Төлөвлөгөөний зорилго.....                                      | 3  |
| 1.1.4. Төлөвлөгөөний хугацаа:  | 4  |
| 1.2 Байгаль цаг уурын төлөв .....                                      | 4  |
| 1.2.2. Ургамалжилт:.....   | 4  |
| 1.2.3. Хөрс:.....  | 4  |
| 1.2.4. Ус зүйн нөхцөл.....   | 5  |
| 1.3 Нийгэм эдийн засгийн нөхцөл .....                                  | 5  |
| 1.3.1 Засаг захиргааны нэгж .....                                      | 5  |
| 1.3.2 Хүн ам .....   | 5  |
| 1.3.3 Дэд бүтэц .....  | 5  |
| 1.3.4 Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, эдийн засаг.....                      | 6  |
| 1.3.5 Мод модон бүтээгдэхүүний хэрэгцээ..                              | 6  |
| 1.4 Хууль эрх зүйн орчин .....   | 6  |
| 1.4.1 Ойн бүсчлэл.....   | 6  |
| 1.4.2 Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар.....         | 6  |
| 1.5 Ойн сангийн төлөв байдал .....                                     | 7  |
| 1.5.1 Ойн талбай .....   | 7  |
| 1.5.2 Модны төрөл.....   | 8  |
| 1.5.3 Нөөц .....   | 8  |
| 1.5.4 Ойн таксацын дундаж үзүүлэлт .....                               | 8  |
| 1.5.5 Ойн сангийн өөрчлөлт.....  | 9  |
| 1.5.6 Ойн сангийн эзэмшлийн байдал.....                                | 9  |
| <b>ХОЁР. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....</b>                      | 10 |
| 2.1 Ой хамгаалал .....   | 10 |
| 2.1.1 Ой, тал хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээ.....              | 10 |
| 2.1.2 Ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх .....              | 15 |
| 2.1.3 Зэрлэг ан амьтан, эмийн ховор ургамал хамгаалалт, ашиглалт ..... | 19 |
| 2.1.4 Хүний хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....        | 20 |
| 2.2 Оиг нөхөн сэргээх .....  | 21 |
| 2.2.1 Байгалийн сэргэн ургалтад туслах.....                            | 21 |
| 2.2.2 Тарьц суулгац ургуулах.....                                      | 23 |

|  |    |
|--|----|
| 2.2.3 Цөлжилтөөс хамгаалах чиглэлээр .....   | 24 |
| 2.3 Агро ойн аж ахуйг хөгжүүлэх, таримал ойн санг бий болгох зорилгоор ойн зурvas байгуулах..... | 29 |
| Хөрс хамгаалах үүрэг бүхий жимсний аж ахуй:.....   | 30 |
| Хадлан бэлтгэх зориулалт бүхий ойн зурvas: .....   | 30 |
| ГУРАВ. САНХҮҮЖИЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ .....   | 33 |
| 3.1 Хөрөнгө оруулалт.....  | 33 |
| 3.2 Жил бүрийн санхүүжилт, түүний эх үүсвэр.....   | 33 |
| 3.3. Ойгоос орох орлого, түүний зарцуулалт.....  | 34 |
| ДӨРӨВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....  | 35 |
| 4.1 Ойн байгууллагын бүтэц.....  | 35 |
| 4.2 Боловсон хүчний чадавх.....  | 35 |
| 4.3 Сургалт, сурталчилгаа.....   | 35 |
| ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, МОНИТОРИНГ .....   | 36 |
| 5.1 Төрийн хяналт.....   | 36 |
| 5.2 Олон нийтийн хяналт.....   | 36 |
| 5.3 Зохиогчийн хяналт .....  | 36 |


## НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

### 1.1 Танилцуулга


#### 1.1.1. Говьсүмбэр аймгийн танилцуулга

Улсын бага хурлын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хот байгуулагдаж, улмаар Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоолоор Говьсүмбэр аймгийг Чойр хотын хилийн цэсээр Сүмбэр, Баянтал, Шивээговь гэсэн 3 сумтайгаар байгуулжээ. Нийт нутаг дэвсгэрийн талбай нь 554179.63км/кв, Хүн ам нь 2017 оны байдлаар 16935. Авто болон төмөр замын босоо тэнхлэгийн сүлжээнд холбогдсон дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Монгол улсын хамгийн залуу аймгийн нэг юм.

**Зураг-1: Говьсүмбэр аймгийн байршил**



**Зураг-2: Говьсүмбэр аймгийн сумдын байршил**



#### 1.1.2. Газар зүйн байрлал

Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт хойд өргөргийн 46057'- 47002', зүүн уртрагийн 1070 57'- 1090 04'-т байрладаг. Хойд талаараа Төв аймгийн Баянжаргалан, Баянцагаан, Баян сумдтай, зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан, Дэлгэрхаан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтал, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг. Улаанбаатар хотоос 220 км-т, зүүн урд зүгт оршдог.

#### 1.1.3. Төлөвлөгөөний зорилго

Монгол улсын “Ойн тухай” хуулийн 9.3, 18.1, 18.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэх, тус аймгийн ойн сан болох Хэрлэн голын дагуух бургасан шугуйг түймэр, хөнөөлт шавж, мал бэлчээрлэлтийн нөлөө болон хууль бус үйл ажиллагаанаас нутгийн ард иргэдийн идэвх оролцоотойгоор хамгаалж, нөхөн сэргээхэд ойн менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

Ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2009 оны 06-р сарын 24-ны өдрийн 70 тоот тушаалын хавсралтаар баталсан “Ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”-ын дагуу боловсруулав.

#### 1.1.4. Төлөвлөгөөний хугацаа:

Говьсүмбэр аймгийн ойн санд 2017 онд хийгдсэн ой зохион байгуулалтын судалгаанд үндэслэн Говьсүмбэр аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөөг 2021-2025 он хүртэл нийт 5 жилийн хугацаагаар төлөвлөн боловсруулав.

### 1.2 Байгаль цаг уурын төлөв

#### 1.2.1. Уур амьсгалын төлөв:

Уур амьсгал бүрэлдэхэд газар зүйн байрлал, нарнаас ирж буй дулааны илч, агаарын орчил хөдөлгөөн, газрын гадарга зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйлс голлон нөлөөлнө. Агаарын температур ба чийгийн нөөц жилд харилцан адилгүй их ялгаатай зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалын байдал тодорхой илэрдэг. Уур амьсгалын мужлалаар хуурай сэргүүтэр зунтай, хүйтэн өвөлтэй мужид хамрагдана. Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал-хээр хосолсон. Говьсүмбэр аймагт жилд унах тунадасны хэмжээ говийн бүсийнхээс илүү /дунджаар 200-250 мм/ бөгөөд температурын ялгаа зундаа +32, өвөл -27 градус байдаг. Уур амьсгалын хувьд хуурайдуу, сэргүүтэр, өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -35 хэм, зуны улиралд хамгийн дулаан нь +32 хэм дулаарах тохиолдол байдаг. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, салхины дундаж хурд 6-12 метр секунд, салхины голлох чиглэл баруун хойноос, хавар, намрын улиралд салхины хурд 28-35 метр секунд хүрэх тохиолдол байдаг. Өвөл орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага байдаг.

#### 1.2.2. Ургамалжилт:

Нутгийн хойд хэсэгт ойт хээрийн ургамал, дунд ба урд хэсгээр нь хээрийн говийн ургамал тархсан. Чойрын Богд уул орчмын нутаг нь ургамал газарзүйн мужлалаар евразийн хээрийн их мужийн умард говийн цөлөрхөг хээрийн хошуу, хээрийн тойрот хамрагдана. Ган халуунд тэсвэртэй, шим тэжээл сайтай, жижиг навчит тачир ургамал голлосон 250 гаруй төрлийн ургамалтай бөгөөд түүний дотор хунчир, алтан-үндэс, дэгд, сэргжмядаг зэрэг олон төрлийн эмийн ургамал элбэг. Гоёо, цулхир, хармаг, вансэмбэрүү, лидэр, алтан гагнуур зэрэг ховор ургамал бий. Гол горхи, булаг шандын ойр орчимд ширэгжсэн хөрстэй газраар алаг өвс-цахилдагт нугажуу хээрийн ургамалтай.

#### 1.2.3. Хөрс:

Говьсүмбэр аймаг нь тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй. Нутгийн хойд хэсгээр хүрэн, өмнөд хэсгээр хүрэн цайвар хөрс зонхилон тархана.

**Хүрэн хөрс.** Хангай, Хэнтийн уулархаг мужид багахан тархаж, харин түүнээс урагш хуурай хээрийн бүсэд эрс зонхилох суурийг эзэлнэ. Хүрэн хөрсөнд ургамал тачир сийрэг, ойролцоогоор хөрсний гадаргын 30-40% нь ургамлаар бүрхэгдэнэ.

Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 20-30см, дээд давхаргын ялзмагийн хэмжээ 2.0-3.5% байна.

*Хүрэн хөрсний морфологийн шинж гэвэл:* Ялзмагийн давхарга сааралдуу буюу гэгээтэй тод хүрэн өнгөтэй, ихээхэн хуурай, тоосорхог мөөгөнцөр бүтэцтэй, элсэнцэр хөрс бол тодорхой бүтэцгүй, хөрсний бүх гадарга сайр чулуугаар элбэг, эсвэл элсэрхэг, ялзмаг үе нь харьцангуй нимгэн, карбонатын ялгарал нэлээд дээрээс эхлэх бөгөөд цагаавтар өнгөр толбо үүсгэж үйрмэг маягаар хуримтлагдана.

#### 1.2.4. Ус зүйн нөхцөл

Тус аймгийн нутагт байнгын ундаргатай Хулгар, Уулзвар, Цоорхой, Хүхээ, Цагаан-Ус, Уст ханан, Шивээ зэрэг 43 ил задгай булаг шанд байдаг ба усан хангамжийн хувьд өрөмдөл богино яндант, энгийн бетонон хашлагатай 246 байгаагаас бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар Сүмбэр суманд 188, Баянтал суманд 8, Шивээговь суманд 28 бүгд 224 худаг ашиглагдаж малчид ард иргэдийн хэрэгцээг хангаж байна.

Усан хангамж бүхий 1538 га газар байгаагаас гол, горхины эзлэх газар 64 га, нуур цөөрөм тойром 1474 га газар буюу аймгийн нийт газрын 0.003%-ийг эзэлж байна.

### 1.3 Нийгэм эдийн засгийн нөхцөл

#### 1.3.1 Засаг захиргааны нэгж

Монгол Улс түүхэн хөгжлийнхөө өнө эртний үеэс засаг захиргааны уламжлалт хуваарътай байжээ. 1912 онд Монгол Улс дөрвөн аймаг, хоёр хязгаар, 129 хошуу, 1923 онд 6 аймаг, 110 хошуунд хуваагдаж, хошууны нутаг дэвсгэр нь тухайн бүс нутгийн байгаль экологийн онцлог болон нүүдлийн мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаатай уялдан зохицсон байсан байна.

#### 1.3.2 Хүн ам

2017 оны статистикийн үзүүлэлтээр 16935 хүн амтай бөгөөд 49.4% нь эмэгтэй, 50.5% нь эрэгтэй, 63.3% нь аймгийн төвд, 26% сумын төвд, 10.7% нь хөдөө амьдардаг. Нийт өрхийг байршилаар нь авч үзвэл аймгийн төвд 2737 өрх буюу нийт өрхийн 59.9%, сумын төвд 797 өрх буюу нийт өрхийн 17.4%, хөдөө багт 1039 өрх буюу нийт өрхийн 22.7%-ийг тус тус эзэлж байна.

#### 1.3.3 Дэд бүтэц

Төв Чойр хот нь Улаанбаатар хотоос 220 км зайдай хатуу хучилттай авто замаар холбогдсон, Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулагийг холбосон босоо тэнхлэгийн авто зам дайран өнгөрдөг.

Хонь, ямаа, үхэр, тэмээ, адууны аж ахуй эрхлэхэд тохиромжтой бөгөөд амьтны аймгаар нэн баялаг, чоно, үнэг, хярс, туулай, мануул, туурайтнаас хар сүүлт, цагаан зээр зэрэг олон амьтан байдгаас дэлхийн улаан номд бичигдсэн ховор ан амьтан аргал багагүй тоогоор байдаг.

### 1.3.4 Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, эдийн засаг

Говьсүмбэр аймагт жижиг дунд үйлдвэрлэл сайн хөгжиж байгаа бөгөөд 2016 оны байдлаар талх, нарийн боов, хэрчсэн гурилын цех 15, бууз, банш мах боловсруулах цех-2, цэвэр усны 3 үйлдвэр үйл ажиллагаа явуулж жилд дунджаар 350-500 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна. Мөн уламжлалт аргаар 1641.8 тонн сүү, 2092.1 тонн мах үйлдвэрлэсэн нь аймгийн нийт жишсэн дундаж хэрэгцээний сүү 100%, мах 100%-ийг хангасан байна. Мөн 402.8 мян.ш өндөг, 97.74 тонн төмс, 117.2 тонн хүнсний ногоо үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн нь дотоодын нийт хэрэгцээний өндөгний 15.7%-ийг, төмсний 14.6%-ийг, хүнсний ногооны 12.3%-ийг хангасан үзүүлэлттэй байна. 2016 онд газар тариалангийн эргэлтийн талбай 74.97 га-д хүрч 6.7 хувиар нэмэгдсэн. Нийт талбайн 23.04 га буюу 30.7%-д төмс 18.3 га буюу 24.4%-д хүнсний ногоо 10.16 га буюу 13.6 %-д тэжээлийн ургамал, 13.268 га буюу 17.7%-д жимсгэнэ тариалж 3 га буюу 4%-ийг уриншилсан, 7.202 га буюу 9.6% нь өнжсөн байна.

### 1.3.5 Мод модон бүтээгдэхүүний хэрэгцээ

Говьсүмбэр аймаг нь ойн сан бага тул хэрэгцээний модоо худалдан авч ашигладаг. Хэрлэн голын дагуух бургасан шугуягаас нутгийн иргэд бага хэмжээгээр түлшний мод бэлтгэдэг.

## 1.4 Хууль эрх зүйн орчин

### 1.4.1 Ойн бүсчлэл

Говьсүмбэр аймгийн ойн сан нь ойн бүсчлэлийн хувьд ойн тухай хуульд зааснаар “Хамгаалалтын бүсийн ой”-д багтаж байгаа бөгөөд Хэрлэн голын дагуух бургасан шугуй нь ойн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 8-р зүйл 8.2 дахь хэсэгт зааснаар “Хориотой зурvasын ой”-д багтаж байна. Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх, гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулах ач холбогдолтой. Хамгаалалтын бүсийн ойд түүнийг хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг сайжруулах зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ахуйн зориулалтаар түлээ бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

### 1.4.2 Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар

Говьсүмбэр аймгаас Улсын тусгай хамгаалалтад Чойрын богд уулыг бүртгэж авсан. 1923 оноос Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуу гэж уулын нэрийг хошууны нэрд оруулж нэрлэж байжээ. Чойрын богд уулыг 1997 онд орон нутгийн тусгай хамгаалалтад, 2011 онд байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад тус тус авсан. Одоогоор тус ууланд 200 гаруй аргаль хонь нутагшиж байна. Ховор ургамал, аргаль, янгир, чоно, үнэг, туулай, цармын бүргэд, идлэг шонхор зэрэг ан амьтан элбэгтэй. Чойрын богд ууланд түүх соёлыг хадгалсан дурсгалууд бий.

## 1.5 Ойн сангийн төлөв байдал


### 1.5.1 Ойн талбай

Тус аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд бүрэлдэхүүний хувьд навчит мод бүхий бургасан ой зонхилно. Ойн сангийн 84% буюу 38 га талбайд байгалийн аясаар ургасан бургасан шугуй, 16% буюу 7 га талбайд тармаг бургас тархан ургасан байна.

Говьсүмбэр аймгийн ойн сан нь бүхэлдээ хамгаалалтын бүсийн ой /гол мөрний дагуух хориотой зурvasын/-д хамаарч байна.

#### Ойн сангийн талбай /газрын төрлөөр/

Бүдүүвч-1



Хүснэгт-1: Говьсүмбэр аймгийн ойн талбай аж ахуйн болон газрын төрлөөр тархах нь

| Модны төрөл   | Ойгоор бүрхэгдсэн |          | Ойгоор бүрхэгдээгүй |                | Бүгд      |
|---|-------------------|----------|---------------------|----------------|-----------|
|   | Байгалийн ой      | Бут сөөг | Тармаг мод          | Огтолсон газар |           |
| <b>Аж ахуйн төрөл: Хэрлэн голын дагуух хориотой зурvasын ой</b> |                   |          |                     |                |           |
| Бургас  | 38                | -        | 7                   | -              | 45        |
| Нийт дүн  | <b>38</b>         | -        | <b>7</b>            | -              | <b>45</b> |

Тайлбар: Ойн сангийн нийт талбайн 84% буюу 38 га талбайд ойгоор бүрхэгдсэн талбай, 16% буюу 7 га талбайд ойгоор бүрхэгдээгүй буюу тармаг мод эзэлж байна.

### 1.5.2 Модны төрөл

*Хүснэгт-2: Байгалийн ойн талбай хэв шинжээр тархсан нь*

| Хэв шинж  | Бургас | Дүн | Хувь |
|---|--------|-----|------|
| <b>Аж ахуйн төрөл: Хэрлэн голын дагуух хориотой зурvasын ой</b> |        |     |      |
| Голын дагуу Үетэн-алаг өвс бүхий Бургасан шугуй                 | 38     | 38  | 100  |
| Бүх дүн   | 38     | 38  | 100  |

Тайлбар: Говьсүмбэр аймгийн ойн сан нь Голын дагуу Үетэн-алаг өвс бүхий ойн хэв шинжид хамаарч байна.

### 1.5.3 Нөөц

Ойн нөөц гэдэг нь 1 га ой дахь ургаа модны ишний эзлэхүүнийг хэлнэ. Хатсан болон унангийн модны нөөц гэдэгт байгалийн болон хүний зохисгүй нөлөөллийн улмаас ойн түймэр болон хөнөөлт шавж, өвчний нөлөөгөөр өсөлт нь зогсож хатсан, унасан модны нөөцийг хамруулна. Ойн нөөцийг тооцоходоо 3-р хүснэгтийг ашиглан тооцсон бөгөөд ойн сангийн нийт нөөц 925 шоо метр гэж тогтоогдов.

*Хүснэгт-3: Ойн талбай нөөц, насны бүлгээр тархах нь*

| Модны төрөл   | Насны бүлэг |      |               |      |                     |      |                        |      | Дүн    |  |
|---|-------------|------|---------------|------|---------------------|------|------------------------|------|--------|--|
|   | Залуу ой    |      | Дунд насны ой |      | Болц гүйцэж яваа ой |      | Болц гүйцсэн хөгшин ой |      |        |  |
|   | Талбай      | Нөөц | Талбай        | Нөөц | Талбай              | Нөөц | Талбай                 | Нөөц |        |  |
| <b>Аж ахуйн төрөл: Хэрлэн голын дагуух хориотой зурvasын ой</b> |             |      |               |      |                     |      |                        |      |        |  |
| Бургас  | 23          | 430  | 15            | 450  | -                   | -    | -                      | -    | 38 880 |  |
| Нийт дүн  | 23          | 430  | 15            | 450  |                     |      |                        |      | 38 880 |  |

Тайлбар: Хүснэгтээс үзэхэд залуу болон дунд насны бургас зонхилон ургаж байна.

### 1.5.4 Ойн таксацын дундаж үзүүлэлт

Ой нь модны төрөл, олон цөөн, нас, өтгөрөл, нөөц болон бусад үзүүлэлтээрээ өөр хоорондоо ялгаатай хэсгүүдээс бүрдэнэ. Нэгэнт дээрх үзүүлэлтүүдээрээ харилцан адилгүй учраас аж ахуйн ач холбогдоороо ч, тэнд авч хэрэгжүүлбэл зохих ойн аж ахуйн арга хэмжээгээрээ бас адилгүй байдаг. Ойг өөр хоорондоо ижил төстэй байдлаар нь ялган тогтоох нь ойн таксацын гол асуудлын нэг бөгөөд түүнийг таксацын үзүүлэлтийн ялгаагаар үндсэнд нь шийддэг.

## Хүснэгт-4: Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлт

| Модны төрөл  | Байгалийн ойн талбай | Бүх нөөц /ш.м/ | Бүх дундаж өсөлт /ш.м/ | Дундаж    |         |         | Ойгоор бүрхэгдсэн талбай 1 га-талааны |             |
|--|----------------------|----------------|------------------------|-----------|---------|---------|---------------------------------------|-------------|
|  |                      |                |                        | Нас /Жил/ | Бонитет | Өтгөрөл | Нөөц /ш.м/                            | Өсөлт /ш.м/ |
| Аж ахуйн төрөл: Хэрлэн голын дагуух хориотой зурвасын ой |                      |                |                        |           |         |         |                                       |             |
| Бургас   | 38                   | 880            | 46                     | 19.09     | V       | 0.55    | 23.15                                 | 1.21        |
| Нийт дүн   | 38                   | 880            | 46                     | 19.09     | V       | 0.55    | 23.15                                 | 1.21        |

Тайлбар: Ойн тансацын дундаж үзүүлэлтээс харахад: Ойн сангийн жилийн бүх дундаж өсөлт 46 шоо метр, дундаж бонитет 5, дундаж өтгөрөл 0.55 га, 1 га-ийн нөөц 23.15 шоо метр, 1 га-ийн дундаж өсөлт 1.21 шоо метр байна.

### 1.5.5 Ойн сангийн өөрчлөлт

Говьсүмбэр аймгийн нутагт хамаарах Бургасан шугуйд өмнө нь ой зохион байгуулалт болон түүнтэй адилтгах судалгааны ажил хийгдэж байгаагүй тул анх удаа хийгдэж байгаа энэ ажлын үр дүнг харьцуулж өөрчлөлт гаргах боломжгүй байна.

### 1.5.6 Ойн сангийн эзэмшлийн байдал

Говьсүмбэр аймгийн ойн сангийн нийт талбай 45га бөгөөд, ойн санг ямар нэгэн аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөлд эзэмшүүлээгүй бүхэлд нь тус суман дахь Сум дундын Ойн анги хариуцдаг.

## ХОЁР. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Ой хамгаалал

Ойн төлөв байдлыг доройтохоос урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоор нөхөн сэргэх боломжийг алдуулахгүйгээр ойн нөөцийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагааг “Ой хамгаалал” гэнэ гэж “Ойн тухай” хуулийн 3.1.9-д тусгасан байдаг.


Говьсүмбэр аймгийн ойн санг хамгаалах ажилд ойн санг түймэр, хортон шавжаас сэргийлэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, тэдгээртэй тэмцэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, бургасан шугуйн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг хангах, удмын санг хамгаалах ажил хамаарна.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Түймрийн харуулын цамхаг бий болгох
2. Бургасан шугуй болон, Малхын тал орчмын отрын бүс нутгийг хариуцуулж тогтмол хараа хяналттай байлгах
3. Түймрээс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийн талаар самбар байрлуулах /хүний хөл хөдөлгөөн ихтэй газруудад/
4. Бургасан ойн хөнөөлт шавжийн мэдээлэл өгөх, сургалт хийх
5. БОАЖГ, СДОА түймэртэй тэмцэх багажаа сайжруулах

#### 2.1.1 Ой, тал хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээ

Өнөөгийн байдлаар онцгой байдлын ерөнхий газраас гаргасан судалгаанаас үзэхэд 2019 онд Улсын хэмжээнд 121 удаагийн ой хээрийн түймэр гарч Улаанбаатар хот, Архангай, Баян-Өлгий, Булган, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Дундговь, Дархан-Уул зэрэг 15 аймгийн 66 суманд нийт 121 удаагийн ой, хээрийн түймэр гарч 311798 га талбай түймэрт өртөж, түймрийн улмаас байгаль экологид 23.756.621.096 төгрөг, түймрийг унтраахад 449.625.850 төгрөгийн зардал гарч нийт 24.206.246.946 төгрөгийн хохирол учирсан байна. Үүнээс үзэхэд ой, хээрийн түймрийн хор хөнөөл хэмжээлшгүй асар их болох нь тодорхой харагдана. Ой, хээрийн түймрийн дийлэнх буюу 95 орчим хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас гардаг болох нь судалгаагаар тогтоогдсон ба үлдэх хувь нь аянга, цахилгаан, хэт халалт зэрэг байгалийн үзэгдлээс шалтгаалдаг байна. Сүүлийн жилүүдийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс үүдэлтэй дулаарлын



улмаас хуурайшилт явагдаж, ган гачиг болж буй зэргээс хавар, намрын улирлаас гадна зуны улиралд ч түймэр гарах үзэгдэл ажиглагдаж байна.

Говьсүмбэр аймаг нь бүхэлдээ тал хээрийн бүсэд хамаарах тул тал хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сумын захиргаа жил бүрийн төсөвтөө тусгаж ажиллах нь зүйтэй.

#### Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

Говьсүмбэр аймаг нь түймрийн эрсдэлийн зэргээр 2, 3, 4-р зэрэгт хамарагдаж байна.

Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ойн тухай хуулийн 3.1.18-д “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс ой хээрийн түймэр үүсэж тархахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа мэдээлэл, сургалт сурталчилгааны болон ойн аж ахуйн арга хэмжээг” хэлнэ гэж заасан.

*Хүснэгт-5: Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

| №  | Гүйцэтгэх ажлын төрөл  | Тоо ширхэг  | Хугацаа       | Хариуцах эзэн  |
|----|--|---|---------------|----------------|
| 1. | Түймрийн пост барих  | 1   | 2022          | БОАЖГ,<br>СДОА |
| 2. | Эргүүл шалгалтыг эрчимжүүлэх   | Хуурайшил<br>ихтэй үед 10<br>хоногт 1, бусад<br>үед сард 1<br>удаа. | 2021-<br>2025 | БОАЖГ,<br>СДОА |
| 3. | Түймрээс урьдчилан сэргийлэх<br>санамж тараах  | 1-2   | 2021-<br>2025 | БОАЖГ          |
| 4. | Түймрээс урьдчилан сэргийлэх<br>самбар босгох  | 5   | 2021          | СДОА           |
| 5. | Тал хээрийн түймрээс<br>сэргийлэх шороон зурvas<br>байгуулах                                     | 5 га  | 2021          | СДОА           |
| 6  | Түймрээс урьдчилан сэргийлэх,<br>түймэртэй тэмцэх үйл<br>ажиллагаанд гарсан зардлыг<br>тооцоолох | Жилд 2 удаа   | Жил бүр       | Санхүүч        |

Тайлбар: Отрын бүс нутаг Малхын тал орчмын газар нутгийг тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тал дээр анхаарч ажиллах

Түймрийн аюулын хор хөнөөлийн талаар яриа таниулга, сургалт сурталчилгааг төв орон нутгийн иргэд, малчид, тухайн ойн сан бүхий нутагт үйл

ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, амарч зугаалж яваа төв орон нутгийн иргэд, сургуулийн сурагчдад хавар, намрын улиралд жилд 1-2 удаа хийнэ. Гал түймэр гарсан тохиолдолд цаг алдалгүй хурдан шуурхай ажиллах зорилгоор түймэр унтраах багаж хэрэгсэл, техникийг сайжруулах хэрэгтэй.

*Зураг-3, 4 Тал хээрийн түймрээс сэргийлэх зурvas /загвар/*



Түймрээс хамгаалах зурвасыг MNS 6530:2015 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

#### *Хүснэгт-6 Түймрээс сэргийлэх шороон зурvas байгуулах тооцоо*

| №        | Шороон зурvas байгуулах | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ       |
|----------|-------------------------|-------------|------------|----------------|----------------|
| 1        | Зурvas байгуулах ажил   | га          | 5          | 230000         | 1150000        |
| Нийт дүн |                         |             |            |                | <b>1150000</b> |

Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх харуулын цамхаг нь гарсан түймрийг газар авахаас өмнө унтраах, орчин тойрноо ажиглах зорилгоор өндөрлөг газар байгуулсан байгууламж юм.

## Зураг- 5, 6 Түймрийн харуулын цамхаг /загвар/



Харуулын цамхгийн хэмжээ өндөр нь газраас дээшээ 20-25 метр байна. Цамхаг барих зардлыг СДОА ойн аж ахуйн арга хэмжээний зардлын дагуу тооцож 2022 оны аймгийн төсөвт суулгаж өгөх.

**Ойн түймэртэй тэмцэх арга хэмжээ:**

Тухайн нутаг дэвсгэрийн ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацааг түймрийн аюултай үе гэж хэлдэг. Монгол орон нь жилийн 4 улиралтай хавар намрын улиралд хур тунадасны хэмжээ багасаж, салхи ихтэй байдаг тул энэ үед түймэр ихээр гардаг. Ойн тухай хуульд 3-р зүйлийн 3.1.17-д түймрийн аюултай үеийг жил бүрийн 3-р сарын 20 өдрөөс 06-р сарын 10-ны өдөр, 09-р сарын 20-ны өдрөөс 11-р сарын 10-ний өдөр хүртэл хэмээн заасан байдаг ч тухайн жилийн орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан энэ хугацаа илүү урт хугацаанд үргэлжлэх тохиолдол бий.

Түймрээс хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлыг “Ойн тухай хуулийн 39.7-д” зааснаар аймаг, нийслэл, сум, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгаж өгнө.

*Хүснэгт-7: Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт*

| № | Шаардагдах багаж хэрэгсэл             | Тоо ширхэг |
|---|---------------------------------------|------------|
| 1 | Холбооны хэрэгсэл                     | 2          |
| 2 | Үлээгч аппарат                        | 8          |
| 3 | Ус шүршигч                            | 20         |
| 4 | Усны сав /1500л доoshгүй багтаамжтай/ | 4          |
| 5 | Цурамдагч аппарат                     | 4          |

|   |   |    |
|---|---|----|
| 6 | Моторт хөрөө  | -  |
| 7 | Чиргүүл   | 2  |
| 8 | Галд тэсвэртэй хувцас /цамц, өмд, бээлийн, гутал, малгай/ | 20 |
| 9 | Эмнэлгийн анхны тусlamжийн иж бүрдэл                      | 6  |

Тайлбар: Засгийн газрын 2013 оны 106-р тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан багаж хэрэгсэл, /зарим зургийг оруулав/

Зураг-7: Үлээгч аппарат



Зураг-8: Цурамдагч



Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд оролцож байгаа иргэдэд зайлшгүй байх ёстой багаж хэрэгслийн талаар Засгийн газрын 2013 оны 106-р тогтоолын 3 дугаар хавсралтад: Ой хээрийн түймрийг унтраахад оролцож иргэдийн хувийн хангамжид байх зүйлс, заавал эзэмшсэн байх арга техник:

1. Түймрийг унтраах ажилд оролцож байгаа иргэдийн хувийн хангамжид байх зүйлс:
  - Галд тэсвэртэй материалаар хийсэн хөнгөн дулаан хувцас
  - 2\*2 м-ийн хэмжээтэй брезентэд нөмрөг
  - Эмийн сан
  - Резиний цохиур, эсвэл бага оврын хүрз
2. Түймрийг унтраах ажилд оролцож байгаа иргэдийн заавал эзэмшсэн байх арга техник
  - Түймэр унтраах багаж хэрэгслийг ажиллуулах дадлага, чадвар
  - Түймэр унтраах арга, техник болон хөдөлмөр аюулгүйн үйл ажиллагаанд суралцсан байх
  - Түймэр унтраах үед түлэгдэж, гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусlamж үзүүлэх чадвар,

Түймэр унтраах ажиллагаанд оролцож буй иргэдийг CS 11-0440:2020 стандартын шаардлага хангасан хувцсаар хангах нь зүйтэй.

### **2.1.2 Ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх**

Ойн хөнөөлт шавжийн нөлөөгөөр модонд үүсэх гэмтэл нэг талаас ургамлын ямар эрхтэн, эрхтний аль хэсгийг гэмтээсэн нөгөө талаас хөнөөлт шавжийн амны бүтэц, хооллолтын хэлбэр, амьдралын хэлбэрээс хамааруулан ангилдаг.

Гэмтлийн үндсэн хэлбэрүүдийг дурдъя.

- навч, шилмүүсийг бүрэн ба хэсэгчлэн идэх, үндэс, найлзуурыг мэрэх, тастах
- навчны зөвлөн эдийг идэж зөвхөн судлыг үлдээх
- мөчир, найлзуур, модлогт зам гаргах, хөндий үүсгэх мөн навч, шилмүүсний зөвлөн эдийг идэж хөндий үүсгэх
- холтсонд зүсэлт хийх, нүх гаргах
- навч, найлзуурыг хуйлах, мушгих, шүлсээр татаж ороох
- ургамлын бүх эрхтэн, эрхтний хэсгүүдээс шүүсийг сорох
- навч, нахиа, найлзуур, мөчир дээр ур үүсгэх

Ойн хөнөөлт шавжийг түүний амьдралын хэлбэр, хооллолтын онцлог зэргээс хамаарч дараах экологийн бүлгүүдэд хуваадаг. Үүнд:

- ургамлын үржлийн эрхтний (цэцэг, жимс, боргоцой, үр) хөнөөлт
- тарьц ба нялх ургамлын нахиа, найлзуур, мөчир, иш, үндсийг гэмтээдэг хөнөөлт
- навч, шилмүүсний хөнөөлт
- ишний хөнөөлт хэмээн бүлэглэнэ.

Ойн хөнөөлт шавжийн популяцын тоо толгойг тогтоох нь нэлээд нарийн төвөгтэй юм. Нэг зүйл олшрох үед дагалдаад зарим зүйлийн тоо толгой мөн нэмэгдэж холимог голомт үүсгэдэг.

#### **Ойн хөнөөлт шавж:**

Ойн хээрийн хайгуул судалгааны ажлын явцад ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн бургасан ойн талбай бүртгэгдээгүй байна. Түймэрт шатаж цаашид ургах чадваргүй болсон шатсан, хатсан, унасан модод нь ойн хортон шавж их хэмжээгээр үржих таатай нөхцөл болж өгдөг. Ойн хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээг урьдчилан сэргийлэх, тэмцэж хамгаалах гэсэн 2 бүлэгт ангилна.

2017 оны байдлаар 15 аймгийн 127 суманд ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг хийж, 502.9 мянган га талбайд зайлшгүй тэмцлийн ажил явуулах шаардлагатай байгаа гэсэн судалгааны үр дүн гарсан. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 176.7 мянган га талбайд тэмцлийн ажил явуулсан. Тэмцлийн ажлыг ойн хөнөөлт шавжийн тоо толгойн нягтшилыг бууруулах шаардлагатай талбайн 35.1%-д зохион байгуулсан гүйцэтгэл гарсан.

Говьсүмбэр аймаг нь ойн сангийн талбай бага боловч Хэрлэн голыг дагасан учир голын бургасан шугуйг хортон шавжаас сэргийлэх судалгааг жил бүр хийж

байх шаардлагатай. Ойн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д зааснаар хортон шавжтай тэмцэх зардлыг жил бүр төсөвтөө суулгаж өгөх нь зүйтэй.

Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааг хийхдээ MNS6533:2015 стандартыг дагаж мөрдөх шаардлагатай. Ойн хөнөөлт шавжийн тархалт гэдэг нь тухайн зүйлийн ойн хөнөөлт шавжийн тохиолдох газар нутгийг хэлнэ. Ойн хөнөөлт шавжийг илрүүлэх цуглуулахдаа дараах аргуудыг хэрэглэнэ.

*Ховоогоор шавж цуглуулах:* Энэ арга нь түгээмэл дэлгэрсэн арга юм. Ихэвчлэн бие гүйцсэн шавж эр, эм эрвээхэй цохыг илрүүлж барихын тулд ургамлан бүрхэвчинд 15-20 удаа ховоогоор шүүрдэлт хийнэ. Мөн энэ аргаар модны навч, шилмүүс, нахиа, үр жимсээр хооллодог шавжийг илрүүлж цугуулахад хэрэглэдэг. Ховооны ишийг модны титэмд хүрэхүйц урттай хийнэ. Модны титмийн хэсэгт ховоогоор шүүрдэлт хийж илэрсэн шавжийг цуглуулан үхүүлж хадгална.

*Модны гол ишийг доргиох, мөчрийг сэгсрэх замаар шавж илрүүлж цуглуулах:* Модны титмийн дор  $10 \text{ m}^2$  хэмжээтэй дэлгэц материалыг дэлгэж тавин модыг сэгсэрч, доргион дэлгэц дээр унасан шавжийг цуглуулна. Энэ аргыг хөнөөлт шавж, эрвээхэйн хүрэнцэр, төөлүүр, хүүхэлдэйн шатанд нь илрүүлэхэд өргөн хэрэглэнэ.

*Далд байрлах шавж илрүүлж цуглуулах:* Модны гол иш, мөчир, үр жимс, навчны эдийн дотор амьдардаг шавжийг цуглуулахдаа тэдгээрийг нэг бүрчлэн задалж илэрсэн шавжийг түүж цуглуулна. Энэ аргыг ихэвчлэн гол ишний хөнөөлт шавжийн авгалдай, хүүхэлдэй, ургамлын бөөсийг илрүүлж цуглуулахад хэрэглэнэ.

*Наалдуулагч цагираг хийж шавж илрүүлэх, цуглуулах:* Энэ арга нь модонд наалдуулагч бүслүүр хийж шавж цуглуулах арга юм. Наалдуулагч бүслүүрийг олс, сүрэл, картон цаас, цагираг төмөр зэрэг янз бүрийн материал ашиглан хийж болно. Энэ аргыг ойн голлох хөнөөлт шавжийн нэг сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр зэргийг илрүүлэхэд хэрэглэнэ.

*Гэрлээр урхидан шавж илрүүлэх, цуглуулах:* Энэ нь янз бүрийн гэрлийг ашиглан шөнийн идэвхтэй шавжийг цуглуулдаг арга юм. Энэ аргаар ойн хөнөөлт шавжийн бие гүйцсэн эрвээхэйг илрүүлэхэд хэрэглэнэ.

*Хөрсөнд байгаа шавж илрүүлэх цуглуулах:* Тодрхой хэмжээний эзэлхүүнтэй хөрсний дээжийг хүрз мэтийн багаж ашиглан дээж болгон авч гараараа бутлан илрэх шавжийг түүж дараа нь буталсан хөрсийг шигшүүрээр шигшиж илэрсэн шавжийг цуглуулна. Энэ аргыг хөрсөнд өвөлжсөн Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр, хүүхэлдэйлхээр хөвхөн давхаргад орсон, Якобсоны төөлүүрч эрвээхэйн төөлүүр, мөн хүүхэлдэй зэргийг илрүүлэхэд хэрэглэнэ.

**Хүснэгт-8: Навчит модонд зонхилох хөнөөлт шавж**

| №                        | Шавжийн экологийн бүлэглэл, зүйлийн нэр              | Модны нэр     | Тэмцэх арга  |
|--------------------------|--|---------------|--------------|
| • Навч шилмүүсний хортон |  |               |              |
| 1                        | Бургасны хүр эрвээхэй ( <i>Leucosta salicis L.</i> ) | Бургас/Salix/ | Химиин бодис |

“Ургамал хамгааллын тухай” хуулийн 4-р бүлгийн 13.2.1-д заасны дагуу хортон илэрсэн тохиолдолд тархалт ихсэхээс өмнө сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч наарт хандан мэдээлж байх ба шаардлагатай тохиолдолд тэмцлийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

**Бургасны хүр эрвээхэй – *Stilpnotia salicis Linn***

**Биеийн бүтэц.** Эрвээхэй цагаан өнгөтэй, далавчны дэлгэмэл нь 40-50мм, бор хүрэн сахалтай, хар хөлтэй, бүх бие нь цагаан үсэн бүрхүүлтэй байдаг. Өндөг нь гялтганасан ногоон өнгөтэй, цайвар ногоовтор шингэнээр гадуураа бүрхэгдсэн байдаг. Хүрэнцэр нь их үсэрхэг бөгөөд тууш шар судлуудтай. Биеийн цагариг бүр дээр 6-8 улаан, цэнхэр толботой тэр нь багц улаан өнгөтэй, 50 мм урт биетэй. Хүүхэлдэй хар хүрэн өнгөтэй, алтлаг шар үсээр хучигдсан, 24-26 мм урт байна.



**Биологийн онцлог.** Энэ эрвээхэй нь өдрийн цагт бургасны иш, мөчир, навчны сүүдэр талд нуугдаж байгаад орой нар жаргаснаас хойш идэвхжин нисэж эвцэлд ордог. Эмэгчин эрвээхэй модны мөчир, навч, иш, холтсон дээр өндгөө багц багцаар шахна. Багцад дунджаар 30-80 ширхэг өндөг байх бөгөөд нэг эмэгчин шавж 700 орчим өндөг гаргадаг.

Амьдралын тохиромжтой нөхцөл бүрэлдвэл 1100 хүртэл өндөг гаргах чадвартай. Эрвээхэйн өндөглөх явц 15-25 хоног үргэлжилдэг. Өндөгний хөгжлийн шатандаа өвөлждөг. Дараа жилийн хавар бургас нахиалах үеэр өвөлжсөн өндөгнөөс хүрэнцэр бий болон бургасны шинэхэн ургаж буй нахиагаар хооллоно. Хүрэнцруүд 30-35 хоног амьдарч бургасны навчаар хооллож байгаад хүүхэлдэй болон хувирна. Томорсон хүрэнцруүд бургасны мөчрийг өөрийн мяндаслаг цагаан шүлсээр холбож торон үүр бэлдээд түүн дотроо хүүхэлдэйд хувирна. Томорсон хүрэнцруүд бургасны мөчрийг өөрийн мяндаслаг цагаан шүлсээр холбож торон үүр бэлдээд түүн дотроо хүүхэлдэйд хувирна. Хүүхэлдэйнээс 8-15 хоногийн дараа эрвээхэй гарч эвцэлд орно. Жилд нэг үе удам өгдөг.

**Хөнөөл.** Хүрэнцэр нь 30-35 хоногийн хугацаанд бургас, улиас мэтийн навчит мод, бутанд ихээхэн гэмтэл учруулах бөгөөд идэгдсэн навч тэр жилдээ сэргэн ургана.

Харин дахин давтагдан идэгдсэн модны өсөлт удааширч зарим жилд олширсон үедээ навчит ойг нүцгэлэн иднэ.

### Бургасны навчич цох – *Galerucella lineola Fr*



Цох нь хар бараан өнгөтэй, дээд далавчиндаа олон жижиг цэгтэй, духны хэсэг ногоон шаргал, эрх хэлбэрийн сахалтай, хөлийн сарвуу бүдэг шар, 5-6 мм урт. Авгалдай улбар шар өнгөтэй, цээж, толгой, хэвлийн цагариг дээрээ хар цэгтэй, биеийн урт 10-12 мм байна.

Бургас ид ургаж эхэлдэг 4 дүгээр сарын сүүлч 5 дугаар сарын эхээр цох бие гүйцэж шинэхэн навчаар хооллож эхэлдэг. Ичээнээс гарсан цохнууд 10-16 хоногийн дараа нэмэлт тэжээл хэрэглэсний дараа эвцэлд ордог. Эвцэлд орсны дараа эм цох 3-6 хоног дахин нэмэлт тэжээл хэрэглээд 10-30ш өндгийг багц багцаар нь бургасны навчны доод гадаргад шахна. Цохны өндөглөх хугацаа 20-30 хоног үргэлжлэх бөгөөд нэг эмэгчин цох 200-500 өндөг шахах чадвартай байдаг. Өндөг нь 10-20 хоногт авгалдайд шилждэг бөгөөд 30-45 хоногийн туршид бургасны навчаар хооллох бөгөөд уг хугацаандаа гурван удаа гууждаг. Авгалдай нь 7 дугаар сарын дундуур хүүхэлдэйн шатанд шилжиж 12-20 хоногийн дараа бие гүйцсэн цоход шилждэг. Уг цохны талаар нарийвчлан судлагдаагүй. Манай орны бургасан шугуй бүхий Орхон, Туул, Сэлэнгэ, Тамир, Эг, Тарвагатай, Онон голын ай саваар тархсан байдаг.

**Хөнөөл.** Цох болон авгалдайнууд бургас, шар хуайсын навчаар зонхилон хооллохоос гадна их үржсэн жилдээ навчийг идэж зөвхөн гол судсыг үлдээдэг хортон юм.

*Хүснэгт-9 Хөнөөлт шавжаас ойг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө*

| №  | Гүйцэтгэх ажлын төрөл   | Ажлын тоо ширхэг /удаа/ | Хугацаа   | Хариуцах эзэн |
|----|---|-------------------------|-----------|---------------|
| 1  | Ойн санд хөнөөлт шавжийн судалгаа хийх  | 1                       | 2021-2025 | БОАЖГ, СДОА   |
| 2  | Хортон шавжийн голомт үүссэн тохиолдолд тэмцэх ажлыг зохион байгуулах                     |                         | 2021-2025 | БОАЖГ, СДОА   |
| 3. | Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд гарсан зардлын тооцоо хийх | 1                       | 2021-2025 | БОАЖГ, СДОА   |

**Ойн хөнөөлт шавжтай тэмцэх арга:** Ойн хөнөөлт шавжтай тэмцэх 3 арга байдаг.

Үүнд:

1. Биологийн арга
2. Химийн арга
3. Механик арга

*Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх:* Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх гэдэг нь хүрэнцэр, авгалдай гол ишээр дамжин титэм рүү гарах, хөрс рүү буух үед түүний камд saatuuлан наалдамхай бодисоор наалдуулан бөөгнөрсөн хүрэнцэр, авгалдай, өрөөсгөл хүр эрвээхэйг бөөгнөрөн өндөглөсөн үед нь гараар түүсэн өндөг, гэрэл болон феромонт урхинд татагдан ирж урхинд орсон эрэгчин эрвээхэйг цуглуулан авч хөрсөнд булах шатаах зэргээр устгахыг хэлнэ. Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд MNS6537:2015 стандартыг мөрдөн ажиллана.

*Ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэх:* Ойн хөнөөлт шавжтай химийн бодис ашиглан үүргийн шүршигч багаж, эсвэл агаарааын хөлөг ашиглан тэмцэх ажлыг хэлнэ. Ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэх ажилд MNS6536:2015 стандартыг мөрдөн ажиллана.

Бургасан ойн хөнөөлт шавжтай тэмцэх гол арга нь химийн арга юм. Үүргийн шүршигч багаж, Утаат үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэж болно. Ойн хөнөөлт шавжтай тэмцэхдээ “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS6532:2015 стандартыг баримтлан тэмцлийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Зураг- 9, 10: Утаат болон үүргийн шүршигч багажаар тэмцэх



### 2.1.3 Зэрлэг ан амьтан, эмийн ховор ургамал хамгаалалт, ашиглалт

Говьсүмбэр аймгаас Улсын тусгай хамгаалалтад Чойрын богд ууланд 200 гаруй аргаль хонь нутагшиж байна. Ховор ургамал, аргаль, янгир, чоно, үнэг, туулай, цармын бүргэд, идлэг шонхор зэрэг ан амьтан элбэгтэй. 250 гаруй төрлийн

ургамалтай бөгөөд түүний дотор хунчир, алтан үндэс, дэгд, сэргмядаг зэрэг олон төрлийн ховор эмийн ургамал ургадаг. Ан амьтан агнах нь Монгол улсын эрүүгийн тухай, ан амьтны хууль тэдгээрийг дагалдан гарсан тогтоол журмаар зохицуулагддаг. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг авах ба хүсэлтээ гаргаж зохих төлбөрийг төлснөөр зөвшөөрөл олгогдоно. Төлбөрийг Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор тогтоосон байдаг. Төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилд амьтан агнах, барихаар тогтоосон дээд хэмжээнд багтаан иргэн, аж ахуй нэгжүүдэд зөвшөөрөл авахгүйгээр амьтан агнах, барихаар тогтоосон дээд хэмжээнд багтаан иргэд зөвшөөрөл авахгүйгээр амьтан агнаж, барих, амьтдын амьдралын онцлогийг харгалзан хуулиар агнах, агнах ашиглахыг хориглосон хугацаанд хууль бусаар ан амьтан агнах, барих зэрэг зөрчил гаргавал эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээнэ.

#### Хүснэгт-10: Зэрлэг ан амьтныг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Гүйцэтгэх ажлын төрөл   | Зорилго                                   | Ажлын тоо хэмжээ, хугацаа                             | Хариуцах эзэн                               |
|---|---|---|---|---|
| 1 | Эргүүл шалгалтыг хийх   | Хууль бус<br>ан<br>агнуураас<br>сэргийлэх | Менежментийн<br>төлөвлөгөөний<br>хугацаанд жил<br>бүр | Байгаль<br>хамгаалагч                       |
| 2 | Зэрлэг ан амьтдын<br>судалгаа хийх                                | Тархалт тоо<br>толгойг<br>тодорхойлох     |   | БОХУБ,<br>СДОА                              |
| 3 | Ан амьтдын бэлчээрийг<br>тогтоож өвлийн улиралд<br>өвс тавьж өгөх | Ан амьтан<br>дайжихаас<br>сэргийлэх       |   | Байгаль<br>хамгаалагч<br>СДОА               |
| 4 | Хяналт шалгалтын үр дүнг<br>танилцуулах                           |   |   | БОХУБ,<br>СДОА<br><br>Байгаль<br>хамгаалагч |

Тайлбар: Эргүүл шалгалт, зэрлэг ан амьтдын судалгааг бусад эргүүл шалгалтын ажилтай уялдуулж, мөн мэргэжлийн судлаач эрдэмтдийн хамтаар хийнэ.

#### 2.1.4 Хүний хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд малчин өрх 798, малчин өрхийн 1826 ам бүлийн гишүүд тоологдсон ба нийт малчид 931, үүнээс эмэгтэй малчид 422 буюу нийт малчдын 45.3 хувийг эзэлж байна. Говьсүмбэр аймаг нь 2019 оны байдлаар 468.4 мянган тоо толгой байна. Тус аймгийн газарзүйн байршлын хувьд аймгийн төвөөсөө хойших газар нутаг ургамлын бүрхэвч, хөрсний бүтцийн хувьд аймгийн төвийн урд хэсгээс илүү сайн тул бэлчээр сайтай байна. Энэхүү байдлаас хамааран Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хойд хагаст байрлалтай Баянтал, Сүмбэр, сумдад малын тоо толгой өндөр байдаг. Хэрлэн голын дагуух бургасан

шугуйд малын даац хэтэrsэн тул бургасан шугуйд байгалийн сэргэн ургалт явагдах боломж байхгүй байна. Сэргэн ургалт явагдаж буй талбайг хашиж хамгаалах хүн болон мал амьтан оруулахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй. 45 га талбай дахь бургасан шугуйг нийтэд нь хаших нь хөрөнгө мөнгө их зарцуулах учир хэсэгчлэн хашиж өгөх.

*Хүснэгт-11: Хашаа барих зардал*

| №        | Хашаа барих материал  | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|-----------------------|-------------|------------|----------------|----------|
| 1        | Шон                   | Ширхэг      | 540        | 4000           | 2160000  |
| 2        | Хашаа барих төмөр тор | Боодол      | 25         | 110000         | 2750000  |
| 3        | Хадаас                | кг          | 10         | 5000           | 50000    |
| Нийт дүн |                       |             |            |                | 4960000  |

Тайлбар: 15 га талбайг хашиж хамгаалах тооцоог оруулж өгөв.

Харин ойн санг тодорхой хугацаатайгаар аж ахуй нэгж байгууллага, иргэдийн нөхөрлөлд гэрээгээр эзэмшиүүлэх нь ойн баялгийг түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалдаг сөрөг үзэгдэлтэй тэмцэхэд иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, бургасан ойг зүй зохистой ашиглах, хамгаалах, үржүүлэхэд онцгой ач холбогдолтой.

## 2.2 Ойг нөхөн сэргээх

Ойн байгалийн сэргэн ургалтын зүй тогтол, өсвөр модны тоо, уур амьсгал, чийг, дулаан, хөрс, их үрийн жилийн давталт зэрэгт үндэслэн ойг нөхөн сэргээх арга хэмжээг хоёр төрлөөр хийнэ. Үүнд:

- Зориудаар ойжуулах
- Байгалийн сэргэн ургалтад туслах

Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээг менежментийн төлөвлөгөөний хугацаанд дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлнэ.

### 2.2.1 Байгалийн сэргэн ургалтад туслах

Мод бэлтгэсэн, түймэр хортонд нэрвэгдсэн ойд үлдсэн мод болон түүний зэргэлдээ ойгоос үр цацагдах буюу хожуулаас ургал эрхтнээр дахин ой болох үйл явцыг ойн байгалийн сэргэн ургалт гэж бөгөөд ойн сэргэн ургалтын нөхцөлийг хүний оролцоотойгоор дэмжин ой буй болгох хугацааг түргэсгэх арга хэмжээг ойн байгалийн сэргэн ургалтад туслах ажил гэдэг.


Говьсүмбэр аймаг нь ойн сан бага тул Хэрлэн голын дагуух бургасан ойн санд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийх нь зүйтэй.

*Хүснэгт-12: Байгалийн сэргэн ургалтад туслах*

| Төрөл                             | Хэсэглэл | Ялгарал | Талбай |
|-----------------------------------|----------|---------|--------|
| Байгалийн сэргэн ургалтанд туслах | 1        | 4, 8    | 7      |
| Аж ахуйн дүн                      |          |         |        |

Тайлбар: Говьсүмбэр аймгийн ойн санд байгалийн сэргэн ургалтад туслах нийт 7 га талбай бүртгэгдсэн байна.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт бүртгэгдсэн Хэрлэн голын дагуух бургасан шугуй нь мал бэлчээрлэлтээс болж сэргэх ургах боломжоор хомс байна. Байгалийн сэргэн ургалтад туслах, нөхөн сэргээх арга хэмжээг 7 га талбайд хэрэгжүүлэх шаардлагатай байна. Сэргэн ургалтад туслах ажилд шаардлагатай тарьц суулгац нь MNS 6141 : 2010 стандартын дагуу тарьж ургуулсан 1-р зэргийн тарьц байна.

*График-1: Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын төлөвлөгөө*

Тайлбар: СДОА өөрсдийн хүн хүчдээ тулгуурлан хийнэ. 2021-2023 онуудад тус бүр 1 га талбайд БСҮ туслах ажил хийж, 2024, 2025 онуудад 2 га талбайд БСҮ-д туслах ажлыг тус тус хийж гүйцэтгэнэ.

**Хүснэгт-13: Байгалийн сэргэн ургалтад туслах ажлын тооцоо**

| №        | Ойн аж ахуйн арга хэмжээ               | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|--|-------------|------------|----------------|----------|
| 1        | Байгалийн сэргэн ургалтанд туслах ажил | га          | 7          | 200000         | 1400000  |
| Нийт дүн |  |             |            |                | 1400000  |

Тайлбар: СДОА өөрсдийн хүн хүчдээ тулгуурлан хийнэ. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 12 сарын 25-ны өдрийн А-368/302 тушаалын хавсралтын дагуу тооцов.

**2.2.2 Тарьц суулгац ургуулах**

Говьсүмбэр аймаг нь 2014 онд 10 га талбайд мод үржүүлгийн газар /МҮГ/ байгуулсан бөгөөд үүнээсээ ердөө 2 га талбайг нь ашиглаж байна. Тус МҮГ-ын бойжуулах талбайд 8160 ширхэг хайлаасны суулгац, улиас сухай 481 ширхгийг мөчрөөр, хүлэмжид үрээр буйлс, агч, шар хуайс зэрэг мод бут сөөгийг үрээр тарьж ургуулж байна.


Цаашид 2021-2025 он хүртэл өөрсдийн МҮГ-aa бүрэн ашиглаж навчит модны тарьц суулгацын нөөцөө ихэсгэж ойжуулалт ойн зурvas байгуулах ажилд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

**Хүснэгт-14: Тарьц, суулгац ургуулах төлөвлөгөө**

| №            | Суулгацын төрөл | 2021 | 2022  | 2023  | 2024  | 2025  | Нийт дүн |
|--------------|-----------------|------|-------|-------|-------|-------|----------|
|              |                 | он   | он    | он    | он    | он    |          |
| Ширхэг тарьц |                 |      |       |       |       |       |          |
| 1            | Улиас           | 700  | 1000  | 1300  | 1600  | 2000  | 6600     |
| 2            | Бургас          | 500  | 700   | 900   | 1100  | 1500  | 4700     |
| 3            | Чацарагана      | 500  | 700   | 900   | 1100  | 1500  | 4700     |
| 4            | Шар хуайс       | 1000 | 1500  | 2000  | 2500  | 3000  | 10000    |
| 5            | Хайлаас         | 3000 | 4500  | 5500  | 6500  | 7500  | 27000    |
| 6            | Буйлс           | 500  | 700   | 900   | 1100  | 1500  | 4700     |
| Нийт дүн     |                 | 6200 | 11119 | 13520 | 15921 | 19022 | 57700    |

Тайлбар: СДОА хүн хүчдээ тулгуурлан өөрийн МҮГ-таа бага хэмжээгээр тарьж ургуулна. /СДОА-с гаргаж өгсөн тоо баримт/

График-2: Тарьц суулгац ургуулах төлөвлөгөө




Тайлбар: СДОА анги жил бүр МҮГ-таа тарьц суулгацыг ургуулснаар цаашид өөрсдийн МҮГ-ын тарьц суулгацаараа ойн зурvas байгуулах ажилд шаардлагатай тарьц суулгацын нөөцтэй болох боломжтой байна.

### 2.2.3 Цөлжилтөөс хамгаалах чиглэлээр

Говьсүмбэр аймаг нь говь, тал хээр хосолсон газар нутагтай. Иймээс цөлжилт элсний нүүлтийг зогсоох зайлшгүй шаардлагатай учир зориудаар ойжуулалт хийх, элсний нүүлтийг зогсоох хамгаалалтын ойн зурvas байгуулах ажлыг жил бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх, мөн өөрсдийн нөөц хүн хүчдээ тулгуурлан хийж байх шаардлагатай. Өмнө хийгдсэн хамгаалалтын ойн зурваст арчилгаа хамгаалалтыг жил бүр тогтмол хийж байх шаардагдах хөрөнгийг аймаг сумын төсөвт суулгаж өгөх.

Зураг-11, 12: Одоо байгаа хамгаалалтын ойн зурvas



**Элсний нүүлт болон цөлжилтийг сааруулах механик арга:** Энэ нь байгалийн болон синтетик материал ашиглан элдэв төрлийн хаалт, саад барих зэргээр гүйцэтгэдэг. Хиймэл хашлага буюу элсэн урсгалыг сааруулах хашилтын систем нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

- Алсын саад буюу бэхжүүлж буй элсэн манхнаас 200-300м зайд байгуулах өндөр хашлага.
- Дундын саад буюу бэхжүүлж буй элсэн манхнаас 100 м доторх орон зайд байгуулах дундаж өндөртэй хашлага.
- Сүрлэн хашлага буюу 1/1 м хэмжээтэй элс баригч дөрвөлжин хамгаалалт

**Механик хамгаалалтын арга:** Элсэн урсгалыг 50 хүртэл хувиар бууруулдаг, хөрсний чийгийг барьдаг, цаашид ургамал ургалтын хөрс уур амьсгалын таатай нөхцөлийг бүрдүүлдэг зэрэг давуу талуудтай. Механик хамгаалалтын дутагдалтай тал нь байгалийн болон синтез ямар ч материал ашигласан энэхүү хамгаалалтын систем нь 4-5жилийн хугацаанд үүргээ гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн дээр заасан хугацааны дараа зайлшгүй шинэчлэх шаардлагатайд оршино. Сүрлэн хашлагыг элсний зоо дагуу сүрлийг газрын гадаргаас дээш 20 см байхаар элсэнд шигтгэх замаар байгуулдаг. Энэ нь 1\*1 м, 2\*2 м, 3\*3 м зэрэг хувилбаруудаар хийгддэг. Шавар даланг элсний зоо дагуу 30-40 см өндөртэйг байгуулдаг. Тууш явах энэ далан нь элсэн манхныг задрах, цаашид давшихаас хамгаалах үүрэгтэй байдаг. Элсийг бэхжүүлэх нягт хашлагыг нэг нь чулуун хамгаалалт үүрэгтэй байдаг. Элсийг бэхжүүлэх нягт хашлагийн нэг нь чулуун хамгаалалт болох бөгөөд үүнийг хавтгай чулуугаар 1\*1 м-ийн дөрвөлжин хашлага байгуулах хэлбэрээр гүйцэтгэдэг. Чулуун хашлага нь янз бүрийн хэлбэртэй байж болно.


**Элсний нүүлтийг сааруулах, цөлжилтийг багасгах биологийн хамгаалалтын арга:** Энэ нь элсний нүүлт хөдөлгөөнийг сааруулах, цөлжилттэй тэмцэхэд хамгийн өргөн дэлгэрсэн, үр дүнтэй аргуудын нэг юм. Цөлжилттэй тэмцэхэд мод сөөг тарих, олон наст ургамлаар ургамалжуулах нь олон нийтэд зөвшөөрөгдсөн арга. Биологийн хамгаалалт нь орчны агаарын температур, чийгийн горимд зохих үүрэг гүйцэтгэдгээрээ зөвхөн элсний нүүлт хөдөлгөөнийг сааруулах ажилд хэрэглэгдээд зогсохгүй цөлжилтийг сааруулах, хөрс уур амьсгалын таатай орчныг бүрдүүлж өгдөг.

**Биологийн хамгаалалт:** Үр цацах, тарьц болон мөчрийн тайрдас суулгах зэрэг аргуудаар хийж болно. Монгол улсын хэмжээнд биологийн хамгаалалтын аргыг 2-3 настай тарьц, суулгац ашиглан туршилт тавьж нэвтрүүлж байна. Хуурай гандуу бус нутгийг ойжуулах үндсэн аргын нэг нь тарьц, суулгацаар ойжуулах арга юм. Энд хамгаалагдсан үндэстэй буюу бортоготой болон ил үндэстэй 2-3 настай тарьцуудыг ашигладаг. Дээр дурдсанчлан биологийн хамгаалалт нь олон янзын үүрэгтэй байх бөгөөд түүнээс хамааруулан тарих хугацаа, тарилтын схем ашиглах тарьц, суулгацын үзүүлэлтүүд зэрэг нь ялгаатай байдаг онцлогтой.

**Тухайлбал:** Салхинаас хамгаалах ойн зурваст 3 ба түүнээс дээш настай 1.5-2 м өндөртэй тарьцуудыг хэрэглэх бөгөөд зурвасын хэлбэрээс нягт, сийрэг, сиймхий хамааруулан мод хооронд 2-5 м, эгнээ хооронд 4-6 м зйтайгаар тооцоолж тарих


ба тарилтын хугацаа 4-р сарын 2 дугаар хагас, 5 сарын эхний 10 хоногоос хэтрэлгүй тарих шаардлагатай.

*График-3: Тэрэгт, Бурхант гэдэг газруудад төлөвлөсөн ойн зурvas байгуулах арга хэмжээ*



Тайлбар: Ойн зурvas байгуулах ажлыг 2021-2023 онд өмнөх онуудад хийгдсэн ойн зурvas дээр нəхəн тарилт хийж, 2023-2025 онуудад shinəer ойн зурvas байгуулна.

*Зураг-13: Ойн зурvas байгуулах талбайн схем зураг*



Тайлбар: 2025 онд хийгдэх хамгаалалтын ойн зурvas байгуулах талбайн схем зураг.

Талбайн хэмжээ: 5 га урт 2500 метр, өргөн 20 метр.

Нийт таригдах модны тоо: 1 га талбайд 600 ширхэг нийт 3000 ширхэг тарьц орно.

**Хүснэгт-15: Ойн зурvas байгуулах ажлын тооцоо**

| №        | Ойн аж ахуйн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ   |
|----------|--------------------------|-------------|------------|----------------|------------|
| 1        | Ойн зурvas байгуулах     | га          | 18         | 2.000.000      | 36.000.000 |
| Нийт дүн |                          |             |            |                | 36.000.000 |

Тайлбар: СДОА өөрсдийн хүн хүчдээ тулгуурлан хийнэ. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 12 сарын 25-ны өдрийн А-368/302 тушаалын хавсралтын дагуу тооцов. Хэрлэн голын дагуу нутагшсан бургасны тарьц суулгацаар 1 га талбайд 600 ширхгээр тооцогддог стандартын дагуу нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэнэ.

**Навчит модны тарьцаар ойжуулах арга технологи:** ПКЛ-70 анжсаар шан татаж тарьц хоорондоо 2м, эгнээ хооронд 4метр хэмжээтэй нүхэнд улиас бургасны суулгацыг суулгана. Мод тарих нүхээ MNS6258-1:2011 стандартын дагуу хийнэ. Суулгахын өмнө тарьц суулгах нүхээ бэлдэж /нүхний диаметр 80 см, өндөр 50-60 см/ байвал болно. Нүхэнд хийх шороогоо урьдчилан бууцтай хольж бэлдээд суулгацаа нүхнийхээ ханан талд нь эгц босоо барьж бууцтайгаа хольсон шороогоо хийж сайтар чигжиж өгнө. Улиас, бургас нь ургах орчны нөхцөлд амархан дасан зохицож хурдан ургадаг. Улиас, бургас нь хөвсгөр хөрсөнд ургахдаа сайн, хөрсний усны түвшин 1-2 метрийн гүнд байвал сайн, чацаргана ус чийг сайтай элсэргэг хөрсөнд илүү дуртай сайн, шаварлаг хөрсийг тэсвэрлэх чадвар султай ургамал юм. Ойжуулалтын ажилд шаардлагатай тарьц суулгац нь MNS 6141 : 2010 стандартын дагуу тарьж ургуулсан 1-р зэргийн тарьц байна.

**Хүснэгт-16: Навчит төрлийн модны суулгацаад тавих шаардлага**

| Д/д | Үзүүлэлт      | Хэмжээ ба шаардлага  |           |           |
|-----|---------------|--|-----------|-----------|
|     |               | 1-р зэрэг  | 2-р зэрэг | 3-р зэрэг |
| 0   | 1             | 2  | 3         | 4         |
| 1   | Гадаад байдал | Гадна талын байдал, өнгө, хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахия задраагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр эгц шулуун, бат бөх үндэс ихтэй, ёсөлт сайтай байна. | Адил      | Адил      |
| 2   | Хэлбэр        | Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд нь ишний нийт уртын 2/3-г   | Адил      | Адил      |

|   |   | эзэлсэн байна.   |  |  |
|---|---|--|--|--|
| 3 | Хэмжээ  |  |  |  |
|   | а. Үндсэн мөчрийн тоо                                   | 10-13<br>1.6-2.0   | 8-10<br>1.2-1.5  | 7-8<br>0.8-1.0   |
|   | б. Титмийн тэлэлтийн голч метрээр                       |  |  |  |
|   | в. Суулгацын өндөр, метрээр                             | 0.7 ба дээш<br>1.5 ба дээш<br>1.5 ба дээш<br>0.8 ба дээш<br>0.8 ба дээш<br>1.2 ба дээш<br>1.0 ба дээш<br>0.8 ба дээш | 0.5-0.7<br>1.0-1.5<br>1.0-1.5<br>0.6-0.8<br>0.6-0.8<br>0.8-1.2<br>0.7-1.0<br>0.6-0.8 | 0.4-0.5<br>0.8-1.0<br>0.8-1.0<br>0.4-0.6<br>0.4-0.6<br>0.6-0.8<br>0.5-0.7<br>0.4-0.6 |
|   | Хус   |  |  |  |
|   | Улиас   |  |  |  |
|   | Улиангар  |  |  |  |
|   | Тоорой  |  |  |  |
|   | Жигд  |  |  |  |
|   | Ледебурын бургас  |  |  |  |
| 4 | Агч   |  |  |  |
|   | Хайлаас   |  |  |  |
| 4 | Үндэс   | Өсөлт хөгжилт сайтай, 3-аас бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой хамт авна.  | Адил   | Адил   |
|   | а. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч, метрээр   | 1.2-1.4  | 1.1-1.2  | 0.9-1.0  |
|   | б. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн зузаан, метрээр | 0.50-0.55  | 0.45-0.50  | 0.40-0.50  |

Үндэстэй хамт авсан шорооны чийг алдагдуулж болохгүй.

Суулгацыг газар гэссэний дараа 4-р сарын 20-оос 5 сарын 25-ны дотор ургалт зогсооны дараа 10 сарын 1-ээс 11-р сарын 1-нийг хүртэл тус тус суулгасан байна.

Суулгацыг байрлуулах нүхний голч ба гүнийг энэ стандартын хүснэгтийг 4а ба 4б зүйлийн дагуу зэрэг тус бүрд заагдсан хэмжээгээр бэлтгэх ба ёроолд нь үржил шимтэй хар шороог 20-оос 25см-ээс доошгүй зузаантайгаар голд шовойлгож асгасан байна. Суулгацыг байрлуулсны дараагаар хар шороогоор сайн чигжиж, ханатал услах ба эгц ургуулахын тулд гувар ба титмийн уулзварт даавуу буюу шуудуугаар мөчир үйс, холтсыг гэмтээхгүйгээр 1 см-ээс доошгүй зузаан, 5см өргөн даавуу шуудайгаар зөөллөн ороож төмөр утас буюу олсоор 3 зүгт тэлэн татаж бэхэлнэ.

### Суулгацыг хүлээн авах

- Нийлүүлэгчээс хүлээн авах суулгацын чанарыг энэ стандартын шаардлагын дагуу нэг бүрчлэн шалгаж хүлээн авна.
- Суулгацын чанар нь стандартын шаардлагын хангахгүй бол нийлүүлэгчээс хүлээн авахыг зөвшөөрөхгүй.
- Хэсэг бүхэнд суулгацын паспорт дагалдах ёстой. (Паспортын агуулга нь хавсралт маягтын дагуу хийсэн байна)

### Хадгалах савлах , тээвэрлэх

- Суулгацын шороотой хэсгийн өөрийн чийгийг алдагдуулахгүйгээр нүх, шуудуунд хийж, хадгалах бөгөөд хөлдөх ууршихаас хамгаалж малын бууц, хар шороогоор хучсан байвал зохино.
- Энэ стандартын хүснэгтийн 4а ба 4б зүйлд зааснаар суулгацын үндэс, шороотой хэсгийг шуудуу буюу модон хайрцагт хийж савлана.
- Суулгацыг авто машинаар тээвэрлэхэд нэгдүгээр зэргийн нэг машинд 1-ээс 2 ширхэг, 2-р зэргийг 10-аас 15 ширхэг, 3 дугаар зэргийг 20 ширхээс дээшгүйгээр тус тус ачна. Ачихдаа машины тэвшний ёроолд 40-ээс 50 см үртэс эсвэл 25-аас 30 см зузаантай хар шороо, малын бууц дэвсэж зөөллөнө. Тээвэрлэхдээ үндсийг хучиж, усалж тээвэрлэнэ. Суулгацыг суулгах хүртэл хугацаанд тогтмол чийгтэй байлгана. Нэгдүгээр зэргийн суулгацын үндэстэй талыг жолоочийн бүхээг рүү харуулж хэвтүүлээд суулгацын үзүүрийн дамнах хэсгийг 5 см-аас доошгүй зузаантай зориулалтын материалыар зөөллөж тээвэрлэнэ.
- Автомашинд 2 ба 3 дугаар зэргийн суулгацыг хооронд хавиралдахгүйгээр босоо байдлаар ачиж мөн дээрхийн адил тэвшний ёроолд зөөлөвч дэвсэж ачна
- Суулгацыг авах, суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтална.
- Суулгацын хэсэг бүхэнд хавсралтад дурдсан паспортын дагалдуулна.

### 2.3 Агро ойн аж ахуйг хөгжүүлэх, таримал ойн санг бий болгох зорилгоор ойн зурvas байгуулах

Ойн зурvas байгуулах ажлыг газар тариалан болон мал аж ахуйтай хослуулснаар байгаль орчинд учрах эрсдэлийг бууруулах боломжтой. Тухайлбал хөрсний элэгдлийг бууруулах, үер усны аюулаас хамгаалах, усны нөөцлөлтийг нэмэгдүүлдэг мөн мал бэлчээрлэлтэд таатай нөхцөлийг бий болгодог. Мод тарих ойн зурvas байгуулах ажил нь хөрсийг баяжуулдаг, хөрсний гүн давхаргуудыг эрдэс минералуудаар хангадаг. Ялангуяа буурцагт төрлийн ургамлууд хөрсийг азотоор баяжуулж өгнө. Модноос унасан навч, шилмүүс зэрэг нь өнгөн хөрсийг хамгаалж, баяжуулж, ялзмагийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Агро ойн аж ахуй нь хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлж мөн хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн улирлаас хамааралтай байдаг хоол хүнсний аюулгүй байдлын хангамж, хоол хүнсний төрөл зүйлийг ихэсгэх мөн хөдөө орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, уур

амьсгал буюу цаг агаарын элдэв аюултай үзэгдлүүдэд тэсэж үлдэх тэрхүү чадварыг нэмэгдүүлнэ.

НҮБ-ын Ур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын талуудын 2011 онд хуралдсан 17-р бага хурлаар аgro ойн аж ахуй эрхлэх нь ур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход ихээхэн чухал нөлөөтэй болохыг мөн хөдөө аж ахуйн салбарын бүрэлдэхүүнд аgro ойн аж ахуй эрхлэлтийг дэмжиж хөгжүүлэх стратеги боловсруулан ажиллах нь ихээхэн чухал ач холбогдолтой болохыг дурдсан байдаг.

Мөн НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцоос аgro ойн аж ахуй нь цөлжилтийн үйл явцыг хяналтад байлгадаг бөгөөд, аgro ойн аж ахуйг хөгжүүлж цөлжсөн газрыг нөхөн сэргээх бүрэн боломжтой болохыг цохон тэмдэглэсэн байна. Биологийн олон янз байдлыг хамгаалах конвенцод ялангуяа ургамлыг хамгаалах дэлхий нийтийн стратегид аgro ойн аж ахуйг эрхэлснээр экосистемийн эрүүл байдлыг хангахад чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглэсэн байна.

**Аgro ойн аж ахуйн маш олон төрөл байх боловч Говьсүмбэр аймагт:**

- Хөрс хамгаалах жимсний аж ахуй хөгжүүлэх зорилгоор ойн зурvas байгуулах
- Хадлан бэлтгэх зориулалт бүхий ойн зурvas байгуулах аgro ойн аж ахуй тохиромжтой.

#### **Хөрс хамгаалах үүрэг бүхий жимсний аж ахуй:**

Жимс жимсгэний аж ахуйг цөлжилтөөс хамгаалах, голын эрэг, усны эх, ундаргыг хамгаалах, элсний нүүлтээс хамгаалах зорилгоор зурvas хэлбэрээр болон, төгөл ой хэлбэрээр тариалдаг. Тухайн нөхцөл байдалтай уялдан талбайн хэмжээ хэд ч байж болдог. Тус менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 20 га талбайд цаашид хэдэн га талбайд хөрс хамгаалах үүрэг бүхий жимсний аж ахуй байгуулах нь 2021-2025 оны хугацаанд багтаагүй учир цаашид төлөвлөгдөх менежментийн төлөвлөгөөнд тусгаж зардлын тооцоог оруулах шаардлагатай.

#### **Хадлан бэлтгэх зориулалт бүхий ойн зурvas:**

Хамгаалалтын ойн зурvasыг байгуулахдаа хашааг нь хадлан бэлтгэх талбайг оруулж томруулж барих бөгөөд зурvas хооронд зайд үлдээж хадлангийн талбай гаргаж өгнө.

Хамгаалалтын ойн зурvas бий болсоны дараа бичил ур амьсгал сайжирч, хөрсний бүтэц өөрчлөгдөн хадлан сайн ургах болно.

Тус менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 20 га талбайд цаашид хэдэн га талбайд хадлан бэлтгэх зориулалт бүхий ойн зурvas байгуулах нь 2021-2025 оны хугацаанд багтаагүй учир цаашид төлөвлөгдөх менежментийн төлөвлөгөөнд тусгаж зардлын тооцоог оруулах шаардлагатай.

Говьсүмбэр аймгийн байгаль цаг уурын онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэж менежментийн төлөвлөгөөний хугацаанд 20 га талбайд хийхээр төлөвлөв. Тус ажил нь 5 дарааллаас бүрдэнэ. Үүнд:

- Талбай сонгох
- Хашаа барих
- Худаг гаргах
- Тарьц суулгац суулгах
- Усалгаа арчилгаа
- Нөхөн тарилт гэсэн дарааллын дагуу хийгдэнэ

*Хүснэгт-17: Агро ойн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор таримал ойн санг бий болгох*

| №        | Суулгацын төрөл   | 2021 он          | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|----------|---|------------------|---------|---------|---------|---------|
|          |   | Хэмжих нэгж /га/ |         |         |         |         |
| 1        | Талбай сонгох   | 20               |         |         |         |         |
| 2        | Хашаа барих   | 20               |         |         |         |         |
| 3        | Худаг гаргах  | 1ш               |         |         |         |         |
| 4        | Тарьц суулгац<br>суулгаж таримал<br>ойн санг бий болгох |                  | 5       | 5       |         | 10      |
| 5        | Усалгаа арчилгаа  |                  |         |         |         |         |
| 6        | Нөхөн тарилт  |                  |         |         | 10      |         |
| Нийт дүн |   |                  |         |         |         |         |

Тайлбар: Менежментийн төлөвлөгөөний хугацаанд нийт 20 га талбайд агро ойн аж ахуйтай хослуулсан таримал ойн санг бий болгоно.

Хашаа барих, тарьц суулгацыг суулгаж ойн зурvas байгуулах усалгаа арчилгаа, нөхөн тарилтын тооцоог тус бүр бодов.

*Хүснэгт-18: Хашаа барих зардлын тооцоо*

| №        | Хашаа барих материал  | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|-----------------------|-------------|------------|----------------|----------|
| 1        | Шон                   | Ширхэг      | 580        | 4000           | 2320000  |
| 2        | Хашаа барих төмөр тор | Боодол      | 32         | 110000         | 3520000  |
| 3        | Хадаас                | кг          | 15         | 5000           | 75000    |
| Нийт дүн |                       |             |            |                | 5915000  |

Тайлбар: 20 га талбайн хашаа барих зардлыг тооцов.

## Хүснэгт-19: Худаг гаргах зардал

| №        | Зардлын төрөл           | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|-------------------------|-------------|------------|----------------|----------|
| 1        | Өрөмдөх зардал          | метр        | 80-90      | 140000         | 11900000 |
| 2        | Худгийн тоног төхөөрөмж | Иж бүрдэл   | 1          | 1150000        | 1150000  |
| 3        | Худгийн байр барих      | ширхэг      | 1          | 6000000        | 6000000  |
| Нийт дүн |                         |             |            |                | 19050000 |

Тайлбар: Худаг гаргах өрөмдөх зардлыг “Эрдэнэ дрилинг ХХК-ны үнийн ханшаар тооцов”

## Хүснэгт-20: Тарьц суулгац тарих

| №        | Үйл ажиллагааны төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ   |
|----------|-----------------------|-------------|------------|----------------|------------|
| 1        | Тарьц суулгац суулгах | га          | 20         | 2.000.000      | 40.000.000 |
| Нийт дүн |                       |             |            |                | 40.000.000 |

Тайлбар: Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 12 сарын 25-ны өдрийн А-368/302 тушаалын хавсралтын дагуу тооцов. Хэрлэн голын дагуу нутагшсан бургасны тарьц суулгацаар 1 га талбайд 600 ширхгээр тооцогддог стандартын дагуу ойн зурvas байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Говьсүмбэр аймаг нь 2021-2025 оны ойн менежментийн төлөвлөгөөний хугацаанд 20 га талбайд агро ой аж ахуйг хөгжүүлэх, таримал ойн санг бий болгох зорилгоор ойн зурvas байгуулж цаашид хөрс хамгаалах, хадлан бэлтгэх бүхий агро ойн аж ахуйг хөгжүүлж болно.

Зураг-14: Хадлан бэлтгэх зориулалт бүхий ойн зурvas



Зураг-15: Жимсний аж ахуй хөгжүүлэх боломж бүхий ойн зурvas

## ГУРАВ. САНХҮҮЖИЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 3.1 Хөрөнгө оруулалт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны ИТХ-аар батлуулна.

### 3.2 Жил бүрийн санхүүжилт, түүний эх үүсвэр

Байгаль орчны чиглэлээр хийгдэж буй ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Улсын төсвөөр гүйцэтгэх ажлын санхүүжилтийг Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын санхүүжилтийг тухайн аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагад гэрээний нөхцөлийн дагуу шилжүүлнэ.

Ой хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум жил бүрийн төсөвтөө тусгана.

Сум дундын ойн ангийн зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2019 онд дараах ажлууд хийгдсэн.

**Хүснэгт-21: 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд**

| Д/д | Хийгдсэн ажил                                       | Ажлын хэмжээ /га/ | Нийт төсөв | Хийгдсэн он |
|-----|---|-------------------|------------|-------------|
| 1   | Цоорхойн рашааны тохижилт                           | 3.5               | 30.000.000 |             |
| 2   | Цэргийн алдрын хөшөөний тохижилт, ногоон байгууламж | -                 | 38.500.000 | 2019        |
| 3   | Ногоон паспорт, ногоон төгөл                        | 3.5               | 30.000.000 |             |

Тайлбар: Тус аймагт нь 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 3 ажил хийгдсэн.

Говьсүмбэр аймагт тохижилт ногоон байгууламж, ойн зурvas байгуулах чиглэлээр хийгдсэн Цоорхойн рашаан орчмын 2.6 га талбайд ойн зурvas байгуулах ажил хийгдсэн 2020 оны 5 дугаар сарын байдлаар амьдралтын хувь 80% байсан. 1 га талбайд бичил цэцэрлэгийн ажил хийгдсэн.

Цэргийн алдрын хөшөө орчмын ногоон байгууламжийн ажилд 0.4 га талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийж нийт талбайг хашаалж зурvas байгуулж мод тарьсан.

Цоорхойн рашаан орчмын тохижилт, Цэргийн алдрын хөшөө орчмын тохижилтын ажлын арчилгаа хамгаалалт, нөхөн тарилтыг "Бат бадрах дэлгэр" ХХК гэрээний дагуу хийж байна.

Ногоон паспорт Ногоон төгөл аяны хурээнд 3.5 га талбайд ногоон байгууламж, ойн зурvas, бичил цэцэрлэг байгуулах ажил хийгдсэн. Таригдсан модны амьдралтын хувь 2020 оны 5 дугаар сарын байдлаар 85% байсан. Энэ жилийн хувьд арчилгаа хамгаалалтын ажлыг орон нутгийн “Модны эх ургац” нөхөрлөл хийж байна.

### 3.3. Ойгоос орох орлого, түүний зарцуулалт

Говьсүмбэр аймаг нь 2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ой зохион байгуулалтын үр дүнгээр ойн сан нь Хэрлэн голын дагуух 45 га бургасан ой тархан ургадаг. Говьсүмбэр аймаг нь ашиглалтын нөөц байхгүй учир уг төсөлд ойгоос орох орлогын талаар тусгаагүй болно.

## ДӨРӨВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 4.1 Ойн байгууллагын бүтэц

Монгол улсын Засгийн газрын 2000 оны 181-р тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийн дагуу Байгаль орчны алба 2004 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн 4 орон тоотойгоор байгуулагдан, МУ-ын Засгийн газрын 2008 оны 12 сарын 24-ны өдрийн 67 тоот тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Ус, цаг уур, орчны шинжилгээний албатай/ нэртэйгээр ажиллаж байгаад МУ-ын Засгийн газрын 2015 оны 08 дугаар тогтоолоор “Байгаль орчин аялал жуулчлалын газар” нэртэйгээр дэргэдээ /Сум дундын ойн ангитай/ болон үйл ажиллагаагаа явуулж байна.

Одоо тус газар дарга, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3, байгаль хамгаалагч 3, нягтлан бодогч, жолооч нийт 10 орон тоотой, харьяандаа сум дундын ойн ангитайгаар ажиллаж байна. Ойн анги нь дарга-1, техникч-1, сахиул, туслах ажилтан 1, сахиул туслах ажилтан - 2 гэсэн 5 орон тоотойгоор ажиллаж байна.

### 4.2 Боловсон хүчний чадавх

Ойн салбарт судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж дэвшилтэт арга технологи боловсруулах инновациын хөрөнгө оруулалт хийх замаар судалгааны үр дүн, шинэ санаа, дэвшилтэт техник технологийг дэмжиж ажиллах.

### 4.3 Сургалт, сурталчилгаа

Ойн тухай, ойг хэрхэн хамгаалах, тарьж ургуулах, арчлах талаар ард иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлнэ. Ерөнхий боловсролын сургуульд ойн экологийн боловсрол мод тарих ойжуулах, ойн зурvas байгуулах чиглэлээр анхны мэдлэг өгөх.

Байгаль орчны салбарын мэргэжилтэн ажилчдынхаа мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аймагтаа сургалт зохион байгуулах.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойн тухай мэдлэг, ойг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчилж өгнө.

Ерөнхий боловсролын сургууль, Ард иргэдэд менежментийн төлөвлөгөөний хугацаанд буюу 2021-2025 онуудад “Ойжуулалт, ойн зурvas байгуулах, байгаль орчноо хамгаалах талаарх” сургалтыг жил бүр 2 удаа зохион байгуулна. Сургалт зохион байгуулахад гарах зардлыг аймгийн БОАЖГ, СДОА жил бүр төсөвтөө тусгаж өгнө.

## ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, МОНИТОРИНГ

### 5.1 Төрийн хяналт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26-р зүйл 26.1, 26.3-д Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага тавина гэж заасан. Иймд ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч, “Ойн тухай хууль”-ийн 18-р зүйлийн 2 дахь заалт 18.2.2-д заасны дагуу засаг дарга, 18 дугаар зүйлийн 3 дахь заалт 18.3.5-д заасны дагуу СДОА хяналт тавьж ажиллана. Хяналт тавихад шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

### 5.2 Олон нийтийн хяналт

Нийгэм эдийн засгийн хөгжил, ардчилал гүнзгийрэх тусам нийгмийн амьдрал дахь төр засгийн удирдлага оролцоо багасаж иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байна. Ойн сангийн тодорхой хэсгийг хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг ойг ашиглахад биш, ойг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хууль бус огтполыг бүрэн зогсооход чиглүүлэн ажиллах нь чухал. Ойн нөхөрлөл, төрийн бус байгууллага, ард иргэдийг ойн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих боломжоор хангах чиглэлээр дараах аргах хэмжээг авна. Үүнд:

- Ойн хууль тогтоомж, Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг өргөн хүрээтэй сурталчлах
- БОАЖГ, Ойн алба, СДОА-ийн зүгээс иргэдийн нөхөрлөл төрийн бус байгууллага, олон нийтийн төлөөллийг хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих нөхцөл боломжоор хангах
- Олон удаагийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлсэн үнэн бодит мэдээлэл өгсөн иргэд, олон нийт, нөхөрлөл, төрийн бус байгууллагын ажилтнуудыг холбогдох заалт журмын дагуу урамшуулах

### 5.3 Зохиогчийн хяналт

Ойн салбарын бүх үйл ажиллагааны үр дүн, чанарыг сайжруулах, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж шалгах, шалган туслах ажил чухал шаардлагатай байна. Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага, БОАЖГ, СДОА тус тус хяналт тавина. Дээрх хяналтуудыг шат шатанд сайн тавьснаар ойн салбарт тогтвортой менежмент нэвтэрч, ойг хамгаалах, зүй зохистой ашиглахад ахиц гарч экологийн ач холбогдол бүхий эрүүл ой бий болно.